



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 431

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хавсралтад заасан нийт 645,800,000.00 (зургаан зуун дөчин таван сая найман зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий 3 /гурван/ ширхэг автомашиныг “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 09 дугаар сарын 08 өдрийн
43/ дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ "ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)
1	Тоёота Ландкрузейр-200 4143 УБИ, арал-JTMHU01J9K5164805	2019/2020	ш	1	229,000,000.00
2	Тоёота Ландкрузейр-200 5909 УБҮ, арал-JTMHX05J304190742	2019/2020	ш	1	256,800,000.00
3	Ниссан Патрол V62 2228 ОРБ, арал-JNITANY62Z0110757	2020/2020	ш	1	160,000,000.00
	НИЙТ ҮНЭ			3	645,800,000.00
					(зургаан зуун дөчин таван сая найман зуун мянга)